

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ  
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар**

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан журмын дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг элсэлтийн ерөнхий шалгалтад 800 болон түүнээс дээш оноо авсан сурагчдад тэтгэлэг олгох хөтөлбөрийн талаар, сургууль доторх хоол үйлдвэрлэлийн газрыг хувийн хэвшилд түрээслүүлэхгүйгээр өөрсдөө ажиллуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хүүхэд харах үйлчилгээ нь хөдөлмөр нийгэм хамгааллын эрхлэх асуудалд орох нь зөв эсэх талаар, багш нарын цалин нэмэгдэх эсэх талаар, төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардлыг төрөөс дэмжлэг үзүүлэх эсэх талаар, мөн их, дээд сургуулиудыг орон нутагт шилжүүлэх ажил ямар шатанд явж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан Завхан аймгийн Яруугийн хүрээг цэцэрлэгт хүрээлэн болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Монгол Улсын сургуулиудын 1 хүүхдэд ногдох урсгал зардал хоорондоо ялгаатай байгаа талаар, боловсролын үнэлгээг төсөвт тусгасныг хэрхэн зарцуулсан талаар, Шинжлэх ухаан, технологийн сангийн зардлыг нэмсэн нь зөв шийдэл эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг боловсролын салбарын төсөв нэмэгдсэн байгаа хэдий ч сүүлийн 30 жил хүн амын индексээр үзэхэд бага байгаа талаар, санхүүжилтийг тэгш оновчтой хуваарилах зарчим хэр хангагдсан талаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах орчин, техник хэрэгсэл хэрхэн хангагдаж төсөвт туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин 2020-2021 онд алслагдсан бүс нутгийн сурагчдын боловсролын хоцрогдлыг энэ жил хэрхэн нөхөж олгох талаар, дутуу баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгуудыг 2022 онд багтаан дуусгах эсэх талаар тус тус

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй 7 саналын томьёолол гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.6 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ДАМДИНЯМ



